



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/305

Есөнбулаг сум

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн түүхт 80 жилийн ойг 2026 оны 07 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойн арга хэмжээг зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймгийн Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т, бэлтгэл ажлыг сайтар хангаж, арга хэмжээг чанартай зохион байгуулахыг Бугат сумын Засаг дарга (Я.Мятав)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ